



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.1.1, 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Цэнддаваагийн Баяр-Эрдэнийг томилсугай.

2. “Монгол шуудан” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Ц.Баяр-Эрдэнэд даалгасугай.


4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 сарын 25-ны өдрийн
16.1 дугаар тогтоолын хавсралт

**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРАЛД ТӨРИЙН ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ
УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт, Компанийн 2023 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэртэй танилцан дараах арга хэмжээг авч ажиллах. Үүнд:

1.1. Ногдол ашиг тараасан болон хуваарилах талаар гарсан шийдвэр нь Компанийн тухай хууль, Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас гарсан тогтоол, шийдвэрүүдтэй нийцэж буй эсэхэд үнэлэлт өгч, Компанийн санхүүгийн болон нийгмийн өгөөжийн үзүүлэлтийг сайжруулах талаарх үүрэг чиглэлийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад өгөх;

1.2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд үнэлэлт өгч батлан, цаашид Компанийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулахад чиглэсэн байдлаар саналаа өгч оролцох;

1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг чиглэл өгөх;

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөвтэй танилцан, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, саналаа тусгаж оролцох;

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”, Засгийн газрын 2024 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу томилох.